МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 06 өдөр | Дугаар А/749 | Улаанбаатар хот

Сэргээн засах тусламж, үйлчилгээг
хөгжүүлэх чиглэл, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл Мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлийн шалгуур үзүүлэлтийг гуравдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт ойртуулж, нотолгоонд суурилсан сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж зорилтот түвшинд хүрэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /Б.Буянтогтох/-т үүрэг болгосугай.

САЙД С.ЭНХБОЛД

14120158

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06 өдрийн А/749 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ (2021-2026)

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Олон улсын хэмжээнд анагаах ухааны салбар хурдацтай хөгжиж, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт, халдварт бус өвчний өвчлөл нэмэгдэхийн хирээр эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээ цогц бөгөөд чанартай байх асуудал чухлаар тавигдаж байна. Урт болон богино хугацаагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, үйлчлүүлэгч төвтэй, чанартай аюулгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүнд хүргэх нь манай улсын эрүүл мэндийн салбарын төдийгүй дэлхийн олон улс орны эрүүл мэндийн байгууллагын эрхэм зорилго болоод байна.

Монгол Улсын хувьд 2017 оны Дэлхийн Өвчлөлийн Судалгаа, 2018-2020 оны Эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй зүрхний шигдээс, харвалт, цусны даралт ихсэх, зүрх судасны өвчин, зам тээврийн осол, ахуйн осол /унаж бэртэх/, үений үрэвсэл, хүзүү нурууны өвдөлт, булчин, ясны эмгэг, төрөлхийн гаж хөгжил ба нярайн эмгэг, хорт хавдар /элэгний/, сэтгэл гутрал, бухимдал  болон сэтгэцийн эмгэгийн улмаас сэргээн засах тусламж үйлчилгээний хэрэгцээ байгаа нь Монгол улсын хүн амын 7 хүн тутмын 2 нь буюу нийт 990 мянган хүнд сэргээн засах тусламж үйлчилгээ шаардлагатай байгааг харуулж байна. Үүний 230 мянган хүн нь хугаралтай, 110 мянган хүн нь хөдөлмөрийн чадвар алдалттай,100 мянган хүн тутамд яс булчингийн эмгэгтэй 24.4 мянган хүн (23.2-25.6 мянган хүн), мэдрэхүйн эмгэгтэй 7.9 мянган хүн (7.38-8.50 мянган хүн), мэдрэлийн эмгэгтэй 3.21 мянган хүн (3.06-3.38 мянган хүн), сэтгэцийн эмгэгтэй 1682 мянган хүн (1.46- 2.10 мянган хүн), амьсгалын замын архаг эмгэгтэй 501 хүн (385-615 хүн), зүрх судасны эмгэгтэй 373 хүн (294-472 хүн), хавдартай 108 хүн (88.3-131 хүн) байна.

Эдгээр мэдээллүүдээс харахад манай улсад сэргээн засах тусламж үйлчилгээний хангагдаагүй хэрэгцээ их байгаа нь хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлгөөн нь сэргэх боломжтой олон хүн сэргээн засах тусламж, үйлчилгээний гадна орхигдож байгааг харуулж байна.

Одоогоор туслах хэрэгслийн хангамжийн асуудал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагдаж, протез, ортопедийн мэргэжилтэн бэлтгэх боловсролын тогтолцоо байхгүй байгаа зэрэг асуудлаар Боловсрол шинжлэх ухааны яамтай хамтрах зэрэг тулгамдсан асуудлууд гарч байгаа нь салбар хоорондын хамтын

ажиллагааны хэрэгцээ шаардлагыг харуулж байна. Мөн сэргээн засахын эмч, мэргэжилтнүүд туслах хэрэгслүүдийн жор бичих, тохируулах, хэрхэн хэрэглэхийг зааж сургах, давтан үзлэгээр туслах хэрэгсэл тохирч буй эсэхийг шалгах зэрэг алхмуудыг системтэй нэвтрүүлэх нь энэхүү тусламж, үйлчилгээг хөгжүүлэх үндэслэл болж байна.

## ХОЁР. ЗОРИЛГО.

Сэргээн засах тусламж, үйлчилгээг урт болон богино хугацаагаар, нотолгоонд суурилсан цогц байдлаар үзүүлэх, чанартай аюулгүй, үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээний зарчмыг баримтлах замаар олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, хөгжүүлэх.

## ГУРАВ. ЗОРИЛТ.

Үйл ажиллагааны зорилтыг биелүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

1. Сэргээн засах тусламж, үйлчилгээний засаглал, манлайллыг сайжруулах
2. Сэргээн засах тусламж, үйлчилгээний хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
3. Олон улсын жишигт нийцсэн нотолгоонд суурилсан сэргээн засах, тусламж, үйлчилгээг хөгжүүлэх
4. Туслах хэрэгслийн хангамжийг сайжруулах
5. Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж, сайжруулах
6. Олон нийт, нийгэм, хамт олонд түшиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх

## ДӨРӨВ. БАРИМТЛАХ ЗАРЧИМ.

Сэргээн засах тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгч шинэ нөхцөл, байдалд дасан зохицох, алдагдсан чадвараа хэвийн болгох боломжит дээд хэмжээнд хүргэхэд "суралцах" үйл явцад тулгуурлах ба дараах зарчимд үндэслэнэ. Үүнд:

4.1. Үйлчлүүлэгч бүрийн хувь хүний онцлогт тохирсон,

4.2. Зорилгодоо хүрэх дэс дараалал, үе шаттай,

4.3. Цогц бүрдэл байх,

4.4. Багийн хамтын ажиллагаатай,

4.5. Гэр бүл, хамт олны оролцоог хангасан,

4.6. Сэргээн засалт нь өвдсөн цаг мөчөөс эхэлж, нийгмийн харилцаа бүрэн, боломжит дээд хэмжээнд сэргэх хүртэл тасралтгүй үргэлжлэх.

**ТАВ. ХУГАЦАА**. 2021-2026 он

## ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН.

## ДОЛОО. САНХҮҮЖИЛТ.

Үйл ажиллагааг хөгжүүлэхэд улсын төсөв, эрүүл мэндийн дэмжих сан, гадаад дотоодын хандивлагч байгууллагын тусламж, дэмжлэг, хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хэрэгжүүлнэ.

## НАЙМ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Үйл ажиллагааны хэрэгжилтэд дунд болон төгсгөлийн үнэлгээг хийнэ. Үнэлгээг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцан, холбогдох байгууллагыг оролцуулан хийж гүйцэтгэнэ.

## ЕС. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.

## АРАВ. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.

| Товчлол | Тайлбар | Товчлол | Тайлбар |
|---|---|---|---|
| ЭМЯ | Эрүүл Мэндийн Яам | ХНХЯ | Хөдөлмөр Нийгэм Хамгааллын Яам |
| СЗСЗ | Сэргээн Засах Салбар Зөвлөл | БШУЯ | Боловсрол Шинжлэх Ухааны Яам |
| ББСЗСМН | Бие Бялдар Сэргээн Засах Судлалын Монголын Нийгэмлэг | ЭМДЕГ | Эрүүл мэндийн Даатгалын Ерөнхий Газар |
| МББХЗХ | Монголын Бие Бялдар Хөдөлгөөн Засалчдын Холбоо | АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль |
| МХЗХ | Монголын Хөдөлмөр Засалчдын Холбоо | ЭМХТ | Эрүүл мэндийн Хөгжлийн Төв |

| | | | |
|---|---|---|---|
| ХХ | Хувийн хэвшил | СҮХ | Статистикийн Үндэсний Хороо |
| ТББ | Төрийн бус байгууллага | ШУТИС | Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль |
| гАТА | Туслах технологийн түргэвчилсэн судалгаа | МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| ДЭМБ | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага | | |

Эрүүл мэндийн сайдын 2021
оны 12 дугаар сарын 06
өдрийн A/729 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

# СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2026 ОН)

| Д/Д | Стратеги | Д/Д | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Д/Д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэгч байгууллага | | | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүнгийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага | Бусад оролцогч байгууллага | | |
| **ЗОРИЛТ 1. СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАСАГЛАЛ, МАНЛАЙЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХ** | | | | | | | | | | | |
| 1.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлтөд сэргээн засах тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх | 1.1.1. | Сэргээн засах тусламж, үйлчилгээг анхан шатлалд бэхжүүлэх, аймаг, дүүрэгт дагнасан төвүүдийг нэгдсэн эмнэлгийн сүлжээтэй уялдуулан байгуулах | 1.1.1.1 | Аймаг, дүүрэгт дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгуулах | 2022 | ЭМЯ | МСЗ<br>ЭМДЕГ<br>ЭЭХЗГ<br>ЭМХТ | ЭМБ<br>МНХ<br>Олон Улсын байгууллагууд | Батлагдсан тушаал | ЭМС-ын тушаал гарсан байна. |
| | | 1.1.2. | Шатлал бүрийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж, загварчлал гаргах | 1.1.2.1 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/502 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулж, батлуулах | 2022 | ЭМЯ | МСЗ<br>ЭМДЕГ<br>ЭЭХЗГ<br>ЭМХТ | ЭМБ<br>МНХ<br>Олон Улсын байгууллагууд | Батлагдсан тушаал | ЭМС-ын тушаал гарсан байна. |
| | | 1.1.3. | Олон улсын жишигт нийцсэн урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, | 1.1.3.1 | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргах | 2022 | ЭМЯ | МСЗ<br>ЭМДЕГ<br>ЭЭХЗГ<br>ЭМХТ | ЭМБ<br>Олон Улсын байгууллагууд | Батлагдсан тушаал | ЭМС-ын тушаал гарсан байна. |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зарцуулах бодит гүйцэтгэлийн үнэлгээг гаргаж, санхүүжилтыг нэмэгдүүлэх | 1.2.1. | Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зарцуулах бодит гүйцэтгэлийн үнэлгээг гаргах<br><br>Сэргээн засах тусламж, үйлчилгээний зарцуулах санхүүжилтын тогтолцоог сайжруулах | 1.2.1.1 | Сэргээн засах тусламж үйлчилгээний санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын талаар олон улсын болон дотоодын зөвлөхүүдтэй хамтран үнэлгээ хийх | 2022 | ЭМЯ | МСЗ<br><br>ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМХТ | ЭМБ МНХ<br><br>Олон Улсын байгууллагууд | Үнэлгээний үр дүн | Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зарцуулах бодит гүйцэтгэлийн үнэлгээг гарсан байна. |
| | | 1.2.2 | | 1.2.2.1 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолд сэргээн засах тусламж, үйлчилгээний оношилгоо, эмчилгээ, хяналтын бодит өртөгт тулгуурласан санхүүжилтийг тусган батлуулах | 2022-2024 | ЭМЯ | МСЗ<br><br>ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМХТ | ЭМБ МНХ<br><br>Олон Улсын байгууллагууд | ЭМДҮЗ-ийнн тогтоол батлагдсан байна. | Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зарцуулах бодит гүйцэтгэлээр санхүүжиж, хөгжих боломж бүрдэнэ. |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | Ил тод шударга засаглалыг дэмжих | 1.3.1. | Эрүүл мэндийн тогтолцооны бүх түвшинд сэргээн засахын мэдээлэл цуглуулах, хяналт үнэлгээний тогтолцоог бий болгож, жил бүр тогтмол суурь түвшин, хүрэх түвшинг харьцуулан тайлагнах | 1.3.1.1 | ЭМХТ-өөс сэргээн засах тусламж үйлчилгээний тоо мэдээг эрүүл мэндийн бусад тусламж үйлчилгээний нэгэн адил аймаг, нийслэлээр нэгтгэн, Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт-ийн номонд жил бүр дүгнэн нийтлэх тогтолцоог бүрдүүлэх | 2022-2026 | ЭМЯ | МСЗ ЭМХТ | ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМБ МНХ Олон Улсын байгууллагууд | Жил бүрийн сэргээн засах тусламж, үйлчилгээний суурь түвшин, хүрэх түвшинг | ЭМХТ-өөс эмхэтгэн гаргадаг "Эрүүл мэндийн үзүүлэлт"-д сэргээн засах дагнасан болон хавсарсан тусламж, үйлчилгээний тоо мэдээ тусгагдсан байна |
| | | 1.3.2. | Бүх шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд сэргээн засахын мэргэжлийн багтай хамтран ажилласан байдлыг үнэлдэг болох | 1.3.2.1 | Чиглэл бүрээр сэргээн засах мэргэжлийн багтай эмнэлгийн тусламж, үйлчилгээний уялдаа холбоо, хамтын ажиллагааг үнэлэх загварчлал гаргах | 2022-2026 | ЭМБ | МСЗ ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМХТ | ЭМБ МНХ Олон Улсын байгууллагууд | Үнэлгээний загварчлал | Эмнэлгийн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлдэг болсон байна. |
| | | 1.3.3 | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоох тогтоцоог боловсронгуй болгосон байна | 1.3.3.1 | "Эмнэлэг, хөдөлмөр магадлах төв комиссын дүрэм"-д сэргээн засахын мэргэжлийн эмчыг магадлагч эмчид оруулах | 2022-2023 | ЭМЯ ХНХЯ | МСЗ | НДЕГ ЭМБ | Батлагдсан "Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын дүрэм" | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоох тогтоцоог боловсронгуй болгосон байна |
| **ЗОРИЛТ 2. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ** | | | | | | | | | | | |
| 2.1 | Мэдлэг ур, чадварыг нэмэгдүүлэх | 2.1.1. | Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөрийг | 2.1.1.1 | Хэл засалч бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтын системд нэвтрүүлэн | 2024-2026 | ЭМБ БШУЯ | МСЗ ЭМДЕГ ЭЭХЗГ | ЭМБ МНХ | Хөтөлбөр Бэлтгэсэн мэргэжилтний тоо | Хэл засалч бэлтгэгдэн, сэргээн засах тусламж, үйлчилгээг |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчлэн боловсруулах | | мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх | | | ЭМХТ | Олон Улсын байгууллагууд | | цогцоор үзүүлэх боломж бүрдсэн байна. |
| | | | | 2.1.1.2 | Ортез, протезийн техникч бэлтгэх хөтөлбөр боловсруулан сургалтын системд нэвтрүүлэн мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх | 2022-2026 | ЭМЯ<br>БШУЯ | МСЗ<br>МНХ<br><br>ЭМБ<br>АУИДС | ЭМБ<br><br>Олон Улсын байгууллагууд | Хөтөлбөр Бэлтгэсэн мэргэжилтний тоо | Ортез, протезийн мэргэшсэн техникч бэлгэгдсэн байна. |
| | | 2.1.2. | Олон улсын стандартад нийцсэн, нотолгоонд суурилсан сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх ажиллах хүчний чадавхийг сайжруулах | 2.1.2.1 | Сэргээн засах мэргэжлийн салбар зөвлөлийг шинэчлэн батлуулах | 2021-2022 | ЭМЯ | МСЗ<br>МНХ | ЭМБ | Батлагдсан тушаал | Сэргээн засах мэргэжлийн салбар зөвлөлийг шинэчлэн батлуулсан байна. |
| | | | | 2.1.2.2 | Сэргээн засахын төрөлжсөн мэргэшлийн багш нарыг гадаадад сургаж бэлтгэх | 2022-2026 | ЭМЯ<br>ГХЯ<br>ХНХЯ<br>БШУЯ | МСЗ<br>МНХ<br>ЭМХТ<br>АУИДС | ЭМДЕГ<br>ЭЭХЗГ<br>ЭМБ<br><br>Олон Улсын байгууллагууд | Гадаадад сургаж бэлдсэн мэргэжилтний тоо | Сэргээн засахын төрөлжсөн мэргэшлийн багш нарыг олон улсын стандартад нийцсэн мэдлэг, ур чадвартай болсон байна. |
| | | | | 2.1.2.3 | Сэргээн засахын мэргэжилтнүүдийг богино хугацаагаар гадаад улсын чадварлаг эмнэлгүүдэд дадлагажуулан сургах | 2022-2026 | ЭМЯ<br>ГХЯ<br>ХНХЯ<br>БШУЯ | МСЗ<br>ЭМХТ<br>АУИДС<br>МНХ | ЭМДЕГ<br>ЭЭХЗГ<br>ЭМБ<br><br>Олон Улсын байгууллагууд | Гадаадад сургаж бэлдсэн мэргэжилтний тоо | Сэргээн засахын төрөлжсөн мэргэшлийн багш нарыг олон улсын стандартад нийцсэн мэдлэг, ур чадвартай болсон байна. |
| | | | | 2.1.2.4 | ОУ-ын зөвлөхүүд болон гадаадад бэлтгэгдсэн багш нартай хамтран семинар, дадлага | 2022-2026 | МСЗ<br>ЭМХТ<br>АУИДС<br>МНХ | ЭМБ | ЭМБ<br><br>Олон Улсын байгууллагууд | Семинар, дадлага сургалтын тоо, үйл | ОУ-ын зөвлөхүүд болон гадаадад бэлтгэгдсэн багш нартай хамтран |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалт зохион байгуулах | | | | ажиллагаан ы тайлан | семинар, дадлага сургалт зохион байгуулсан байна |
| 2.2 | Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэгч мэргэшсэн хүний нөөцийн хангагдаагүй хэрэгцээг нэмэгдүүлэх | 2.2.1. | Сэргээн засах тусламж, үйлчилгээний мэргэшсэн сургагч багш бэлтгэх | 2.2.1.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээ төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хяналтын тоог бодлогоор нэмэгдүүлэх | 2022-2026 | ЭМЯ<br>БШУЯ | МСЗ<br>ЭМХТ | ЭМБ<br>МНХ<br>Олон Улсын байгууллагууд | Нэмэгдүүлсэн хяналтын тоо | Сэргээн засах тусламж, үйлчилгээ төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хяналтын тоо нэмэгдэж сэргээн засхын хүний нөөцийг хангамж 10-20%-аар сайжирсан байна |
| | | | | 2.2.1.2 | Өвчний цочмог болон цочмогдуу үед сэргээн засахын орны дэргэд тусламж үйлчилгээг үзүүлэх сувилагчдыг мэргэшүүлэн сургаж, гэрчилгээ олгох | 2022-2026 | МСЗ<br>ЭМХТ<br>АУИДС | МНХ<br>ЭМБ | ЭМБ<br>МНХ<br>Олон Улсын байгууллагууд | Семинар, дадлага сургалтын тоо, үйл ажиллагааны тайлан | ОУ-ын зөвлөхүүд болон гадаадад бэлтгэгдсэн багш нартай хамтран семинар, дадлага сургалт зохион байгуулсан байна |
| **ЗОРИЛТ 3. ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН НОТОЛГООНД СУУРИЛСАН СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | | | | | | |
| | Оношилгоо, эмчилгээний | 3.1.1 | Эмнэлзүйн удирдамж боловсруулах, орчуулж хөрсөн дээр буулгах үйл ажиллагаанд мэргэжлийн нийгэмлэг, холбоодыг татан оролцуулах, санхүүжилтыг нэмэгдүүлэх | 3.1.1.1 | Стандарт, удирдамж боловсруулах, турших, нэвтрүүлэх төслийг жил бүрийн төсөвт суулгах | 2022-2026 | ЭМЯ | МСЗ<br>ЭМДЕГ | ЭМБ<br>Олон Улсын байгууллагууд | -Төсөвт суух үндэслэл,<br>-Төсвийн эх үүсвэр,<br>-Батлагдсан төсөв | Стандарт, удирдамж боловсруулах, турших, нэвтрүүлэх төсөв жил бүрийн төсөвт суусан байна, |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийг мөрдөх | 3.1.2 | Олон улсын Үйл ажиллагааны ангилал**** (ICF)-ыг эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсролын салбарт сэргээн засах тусламж үйлчилгээтэй холбоотой баримт бичиг боловсруулж, хэрэгжилтийг хангахад ашиглах | 3.1.2.1 | Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулах | 2022-2026 он | ЭМЯ ХНХЯ | ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМХТ | ЭМБ Олон Улсын байгууллагууд | Журам, заавар | Олон улсын Үйл ажиллагааны ангилал**** (ICF)-ын дагуу Хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулсан байна |
| 3.2 | Эрдэм шинжилгээний ажлыг бодлогоор дэмжих | 3.2.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний зорилго, үр ашиг, үр дүнгийн талаар олон улсын болон дотоодын судалгааг дэмжих | 3.2.1.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний зорилго, үр ашиг, үр дүнгийн талаар олон улсын болон дотоодын судалгаа хийх | 2022-2026 | ЭМБ Олон Улсын байгууллагууд | ЭМХТ АУИДС | - | Судалгааны үр дүн | Сэргээн засах тусламж, үйлчилгээний зорилго, үр ашиг, үр дүнгийн талаар олон улсын болон дотоодын судалгаа хийгдсэн байна |
| | | 3.2.2 | | 3.2.2.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх талаар хэлэлцэх үндэсний хэмжээний уулзалт жил бүр зохион байгуулах | 2022-2026 | ЭМБ | ЭМХТ АУИДС | - | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх талаар хэлэлцэх үндэсний хэмжээний уулзалт жил бүр зохион байгуулсан байна |
| | | 3.2.3 | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, олон нийт сэргээн засахын тусламж, үйлчилгээний талаар олон талт мэдлэгтэй болох | 3.2.3.1 | Нотолгоонд суурилсан судалгаанд үндэслэсэн мэдээллийг агуулсан гарын авлага гаргах, | 2022-2026 | ЭМХТ | ЭМБ | - | Гарын авлага Цахим мэдээллийн сүлжээнд байршсан | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, олон нийт сэргээн засахын тусламж, үйлчилгээний талаар олон |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боломжийг нэмэгдүүлэх | | цахим хуудас нээн ажиллуулах | | | | Олон Улсын байгууллагууд | | |
| 3.3 | Оношилгоо, эмчилгээний Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших | 3.3.1 | Оношилгоо, эмчилгээний Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших боломжийг бий болгох | 3.3.1.1 | Uptodate, DynaMed, Best Practice ..... Гэх мэт Олон Улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших | 2022-2026 | ЭМЯ | ЭМДЕГ ЗЭХЗГ ЭМХТ | ЭМБ | [illegible] | |
| ЗОРИЛТ 4 . ТУСЛАХ ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ | | | | | | | | | | | |
| 4.1 | Өндөр үр дүнтэй, шинэ технологи, эм, эмнэлгийн хэрэгслийг практикт шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. | 4.1.1 | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нэвтрүүлэх журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх | 4.1.1.1 | Туслах хэрэгслийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх | 2021-2022 | ЭМЯ | ЭМХТ Үндэсний статистикийн хороо | ЭМБ | Туслах хэрэгслийн өнөөгийн байдалд үнэлгээний тайлан | [illegible] байдал [illegible] |
| | | | | 4.1.1.2 | Хүн амд түр хугацаанд болон урт хугацаанд хэрэглэх шаардлагатай туслах хэрэгслийн хангамжийг төлөвлөх, эрх зүйн баримт бичиг боловсруулан батлах | 2023-2024 | ЭМЯ ХНХЯ БШУЯ | ЭМБ ЕБС ИДС | - | Батлагдсан тушаал | Хүн амд түр хугацаанд болон урт хугацаанд хэрэглэх шаардлагатай туслах хэрэгслийн хангамжийг төлөвлөх, эрх зүйн баримт бичиг боловсруулан батлагдсан байна |
| | | | | 4.1.1.3 | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж Олон улсын өнөөгийн түвшинтэй харьцуулан дүгнэх | 2022-2023 | ЭМЯ | ЗЭХЗГ ЭМХТ ЭМХТ НЭМҮТ | ЭМБ | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн [illegible] | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж Олон улсын [illegible] |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боломжийг нэмэгдүүлэх | | цахим хуудас нээн ажиллуулах | | | Олон Улсын байгууллагууд | | мэдээллийн тайлан | талт мэдээлэлтэй болсон байна. |
| 3.3 | Оношилгоо, эмчилгээний Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших | 3.3.1 | Оношилгоо, эмчилгээний Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших боломжийг бий болгох | 3.3.1.1 | Uptodate, DynaMed, Best Practice ..... Гэх мэт Олон Улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвших | 2022-2026 | ЭМЯ | ЭМДЕТ ЭЭХЗГ ЭМХТ | ЭМБ | Цахим платформыг хэрэглэж хэвшсэн эмнэлгийн мэргэжилтний тоо | Оношилгоо, эмчилгээний Олон улсын сүүлийн үеийн эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвшсэн байна. |
| **ЗОРИЛТ 4 . ТУСЛАХ ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | | | | | |
| 4.1 | Өндөр үр дүнтэй, шинэ технологи, эм, эмнэлгийн хэрэгслийг практикт шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. | 4.1.1 | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нэвтрүүлэх журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх | 4.1.1.1 | Туслах хэрэгслийн өнөөгийн байдалд үнэлгээ хийх | 2021-2022 | ЭМЯ | ЭМХТ Үндэсний статистикийн хороо | ЭМБ | Туслах хэрэгслийн өнөөгийн байдалд үнэлгээний тайлан | Туслах хэрэгслийн өнөөгийн байдалд үнэлгээ хийгдсэн байна. |
| | | | | 4.1.1.2 | Хүн амд түр хугацаанд болон урт хугацаанд хэрэглэх шаардлагатай туслах хэрэгслийн хангамжийг төлөвлөж, эрх зүйн баримт бичиг боловсруулан батлах | 2023-2024 | ЭМЯ ХНХЯ БШУЯ | ЭМБ ЕБС ИДС | - | Батлагдсан тушаал | Хүн амд түр хугацаанд болон урт хугацаанд хэрэглэх шаардлагатай туслах хэрэгслийн хангамжийн төлөвлөгөө, эрх зүйн баримт бичиг боловсруулан батлагдсан байна. |
| | | | | 4.1.1.3 | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж Олон улсын өнөөгийн түвшинтэй харьцуулан дүгнэх | 2022-2023 | ЭМЯ | ЭЭХЗГ ЭМХТ ЭМХТ НЭМҮТ | ЭМБ | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж Олон улсын өнөөгийн |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | АШУҮИС | | судалгааны үр дүн | түвшинтэй харьцуулан дүгнэсэн байна. |
| | | | | 4.1.1.4 | Шинэ эм, хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, туслах хэрэгслийг нэвтрүүлэх журмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх | 2023-2025 | ЭМЯ | ЭЭХЗГ ЭМДЕГ | ЭМБ | Батлагсан тушаал | Олон улсын жишигт нийцүүлэн чиглэл бүрт 2-оос доошгүй бүтээгдэхүүн шинэчлэгдсэн байна. |
| **ЗОРИЛТ 5. СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ТАСРАЛТГҮЙ ХЭМЖИЖ САЙЖРУУЛАХ** | | | | | | | | | | | |
| 5.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулж тогтмол хэмжих | 5.1.1 | Асуудалд чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг салбарын, бүс нутгийн, байгууллагын, тасаг нэгжийн, хувь хүний болон хөтөлбөрийн түвшинд боловсруулж тогтмол хянах | 5.1.1.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг шинээр (нийтлэг болон өвөрмөц) боловсруулж батлуулах | 2022-2023 | ЭМБ | ЭМДЕГ, ЭЭХЗГ ЭМХТ | - | Шалгуур үзүүлэлт | Бүх түвшинд асуудалд суурилсан 4 төрлийн шалгуурыг үнэлгээнд ашиглаж хэвших |
| | | 5.1.2 | Тулгамдсан ноцтой асуудлыг шийдэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлдэг журмыг батлан хэрэгжүүлэх | 5.1.2.1 | ЭМБ нь тулгамдсан ноцтой асуудлаа шийдвэрлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж тогтмолжуулах | 2022-2026 | ЭМБ | ЭМДЕГ, ЭЭХЗГ ЭМХТ | - | Хөтөлбөр | ЭМБ-ын Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг шинээр (нийтлэг болон өвөрмөц) боловсруулж батлуулах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 5.1.3 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний магадлан итгэмжлэлийн шалгуурын шинэчлэх | 5.1.3.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээг дагнан үзүүлж буй бүх шатны эмнэлгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, сэргээн засах үйл явц, үр дүнд үнэлгээ хийх | 2022 | ЭМЯ | ЭМХТ | ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМБ | Үнэлгээний үр дүн | Сэргээн засах тусламж, үйлчилгээг дагнан үзүүлж буй бүх шатны эмнэлгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, сэргээн засах үйл явц, үр дүнг тодорхойлсон байна. |
| | | | | 5.1.3.2 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний магадлан итгэмжлэлийн шалгуурыг шатлал бүрт тохирсон үзүүлэлтээр шинэчлэн боловсруулах | 2023 | ЭМЯ | ЭМХТ | ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМБ | Батлагдсан шалгуур үзүүлэлт | Сэргээн засах тусламж, үйлчилгээний магадлан итгэмжлэлийн шалгуурын шинэчлэн батлагдсан байна |
| **ЗОРИЛТ 6. Олон нийт, нийгэм, хамт олонд түшиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх** | | | | | | | | | | | |
| 6.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний талаар авч хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах | 6.1.1 | Сэргээн засах тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах боломжийг бүрдүүлэх | 6.1.1.1 | Хамт олонд түшглэсэн сэргээн засах хандлагын удирдамж, заавар боловсруулах | 2022-2023 | ЭМЯ | НЭМҮТ ЭМХТ АШУҮИС | Бусад | Батлагдсан удирдамж, заавар | Сэргээн засах тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдийг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах боломжийг бүрдүүлсэн байна. |
| | | 6.1.2 | Олон нийтэд хүрч буй эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрт сэргээн засах тусламж, үйлчилгээний | 6.1.2.1 | Жил бүр сэргээн засах тусламж, үйлчилгээний ач холбогдлыг танилцуулах | 2021-2026 | ЭМБ | МТГ | Бусад | Олон нийтэд чиглэсэн зохион | Олон нийтийн ойлголт |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухай тогтмол оруулж байх | | өдөрлөг зохион байгуулах | | | | | байгуулсан арга хэмжээ | нэмэгдсэн байна. |
| 6.2 | Эрүүл мэндийн боловсролын толтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг багтаасан байна. | 6.2.1 | Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцооны эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг багтаах | 6.2.1.1 | Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн хөтөлбөрт сэргээн засах, хөгжлийн бэрхшээлийг таниулах модул боловсруулах (Жишээ нь: Хүүхдүүд гар угааж буй зурагт хуудсанд тэргэнцэртэй хүүхдийг оруулж өгөх, туслах хэрэгсэлтэй хүүхдийг ойлгож, дэмжих аяг зохион байгуулж хэвшүүлэх ) | 2021-2026 | ЭМЯ БШУЯ | ЭМХТ АУИДС ЕБС | Бусад | Боловсруулж баталсан хөтөлбөр Зохион байгуулсан арга хэмжээ | Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцооны эрүүл мэндийн боловсролын хөтөлбөрүүд нь хөгжлийн бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг багтаасан байна |

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 06 өдрийн [illegible] дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## “СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ (2021-2026)” -ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ” арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2019, 2020 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашигласан.

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2020 | Хүрэх түвшин (оноор) | | | | | | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | |
| **Үр нөлөөний болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд** | | | | | | | | | | |
| 1 | Сэргээн засах цогц тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо | тоо | 1 | 1 | 3 | | | | 80 | ЭМЯ, ЭМХТ, СЭМҮТ, БСШУЯ |
| 2 | Хөдөлгөөн засалч | тоо | 134 | 147 | 160 | 173 | 186 | 199 | 212 | |
| | Хөдөлмөр засалч | тоо | 14 | 15 | 17 | 19 | 21 | 23 | 25 | |
| | Сэргээн засахын их эмч | тоо | 161 | 164 | 168 | 172 | 176 | 180 | 184 | |
| | Сэтгэл зүйч | тоо | 8 | 10 | 20 | 30 | 40 | 50 | 60 | |
| | Сэргээн засахын сувилагч | тоо | 384 | 401 | 418 | 435 | 452 | 469 | 486 | |
| | Бусад засалч | тоо | 47 | 48 | 50 | 53 | 56 | 60 | 65 | |
| 3 | Тухайн онд сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан хүний тоо | тоо | | | | | | | | ЭМХТ |
| 4 | Uptodate, DynaMed, Best Practice ..... Гэх мэт Олон Улсын эмнэлзүйн удирдамжийн цахим платформыг хэрэглэж хэвшсэн байгууллага | тоо | - | 1 | 5 | 16 | 37 | 137 | 200 | ЭМДЕГ ЭЭХЗГ ЭМХТ |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчдийн тоо | Улаанбаатар | тоо | 36981 | 35731 | 35106 | 34481 | 33856 | 33231 | 32606 | ЭМХТ |
| | | Аймаг | тоо | 73276 | 73065 | 72854 | 72643 | 72432 | 72221 | 72010 | |
| 6 | Шинээр хяналтад орсон хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо | | тоо | 581 | 570 | 565 | 560 | 555 | 550 | 545 | |
| 7 | Сэргээн засах тасагт эмчлүүлсэн хүний тоо | | тоо | 991 | 1312 | 1633 | 1954 | 2275 | 2596 | 2917 | |
| 8 | Сэтгэл засал эмчилгээнд хамрагдсан хүний тоо | | тоо | 14422 | 15122 | 15822 | 16522 | 17222 | 17922 | 18622 | СЭМҮТ |
| 9 | Сэргээн засах эмчилгээ хийлгэсэн хүн/ 10 000 хүн амд/ | Амбулаторт | 10000 хүн амд ногдох | 2193 | 2255 | 2316 | 2378 | 2440 | 2502 | 2564 | ЭМХТ |
| | | Стационарт | 10000 хүн амд ногдох | 1865 | 2485 | 3105 | 3721 | 4341 | 4961 | 5581 | |

**Тайлбар: Мэдээллийн эх үүсвэр**

**** Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2019, 2020, 2021 он*

***** Эрүүл мэндийн мэдээлэл, сарын мэдээлэл, 2019, 2020, 2021 он*

--- oOo ---